



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 39


Улаанбаатар хот

Эрх бүхий албан тушаалтныг  
томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Номин даатгал” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Батсайханы Жавхланцогтыг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллахыг Б.Жавхланцогтод үүрэг болгосугай.
3. Тогтоол батлагдсантай холбоотой Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 273 дугаар тушаалын Идэштогтох овогтой Галбуянд холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН